



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өвөрхангай аймагт барьж, ашиглалтад оруулсан нийт 2,273,137,356.00 (хоёр тэрбум хоёр зуун далан гурван сая нэг зуун гучин долоон мянга гурван зуун тавин зургаан) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилга, дэд бүтцийн байгууламж, холбогдох хөрөнгийг Өвөрхангай аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Н.Ганболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өвөрхангай аймагт бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Н. ГАНБАТ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА



Ц. ТҮВШИНЗАЯА

0000095



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 02 сарын 19-ний өдрийн  
60 дугаар тогтоолын хавсралт

**УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИИ БОЛСОН,  
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Барилга, байгууламж (хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ)-ийн нэр	Хүлээн авч ашиглах төсөвт байгууллагын нэр	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Хөрөнгийн үнэ (төгрөг)
1	Зүүнбаян-Улаан сумын Хад багийн төвийн барилга	Зүүнбаян-Улаан сумын ЗДТГазар	93,422,211.00	93,422,211
2	Сант сумын Цариг багийн төвийн барилга	Сант сумын ЗДТГазар	72,762,932.00	72,762,932
3	Есөнзүйл сумын Найрамдал багийн төвийн барилга	Есөнзүйл сумын ЗДТГазар	72,510,794.00	72,510,794
4	Тарагт сумын 5 дугаар багийн төвийн барилга	Тарагт сумын ЗДТГазар	50,000,000.00	50,000,000
5	Арвайхээр сумын 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга	Арвайхээр сумын 12 дугаар цэцэрлэг	881,009,000.00	881,009,000
6	Бат-Өлзий сумын сургуулийн барилгын их засвар	Бат-Өлзий сумын сургууль, цэцэрлэг	46,935,355.00	46,935,355
7	Хужирт сумын сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар	Хужирт сумын сургууль, цэцэрлэг	47,936,448.00	47,936,448
8	Зүүнбаян-Улаан сумын сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар	Зүүнбаян-Улаан сумын сургууль, цэцэрлэг	99,962,903.00	99,962,903
9	Арвайхээр сумын 3 дугаар цэцэрлэгийн сантехникийн засвар	Арвайхээр сумын 3 дугаар цэцэрлэг	37,512,210.00	37,512,210
10	Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн засвар	Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэг	50,114,824.00	50,114,824
11	Арвайхээр сумын 6 дугаар цэцэрлэгийн засвар	Арвайхээр сумын 6 дугаар цэцэрлэг	44,000,000.00	44,000,000
12	Арвайхээр сумын 4 дүгээр сургуулийн гадна фасадны засвар	Арвайхээр сумын 4 дүгээр сургууль	60,000,000.00	60,000,000
13	Арвайхээр сумын 1 дүгээр сургуулийн барилгын засвар	Арвайхээр сумын 1 дүгээр сургууль	65,306,029.00	65,306,029



Д/д	Барилга, байгууламж (хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ)-ийн нэр	Хүлээн авч ашиглах төсөвт байгууллагын нэр	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Хөрөнгийн үнэ (төгрөг)
14	Арвайхээр сумын 2 дугаар сургуулийн их засвар	Арвайхээр сумын 2 дугаар сургууль	123,334,450.00	123,334,450
15	Арвайхээр сумын 7 дугаар цэцэрлэгийн барилгын их засвар	Арвайхээр сумын 7 дугаар цэцэрлэг	83,000,000.00	83,000,000
16	Гучин-Ус сумын ЕБС-ын дотуур байрны засвар	Гучин-Ус сумын ЕБСургууль	50,000,000.00	50,000,000
17	Тарагт сумын ЕБС-ын хаалга, цонхны шинэчлэлийн засвар	Тарагт сумын ЕБСургууль	30,000,000.00	30,000,000
18	Өлзийт сумын Бизнес хөгжлийн төвийн тохижилт, засвар	Өлзийт сумын ЗДТГазар	28,288,004.00	28,288,004
19	Арвайхээр сумын 2,7 дугаар багийн төвийн барилга	Арвайхээр сумын ЗДТГазар	91,168,054.00	91,168,054
20	Хархорин сумын Халдвартын эмнэлэгийн барилгын их засвар	Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг	148,180,000.00	148,180,000
21	Есөнзүйл сумын сум дундын эмнэлэгийн барилгын их засвар	Есөнзүйл сумын сум дундын эмнэлэг	55,370,000.00	55,370,000
22	Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар	Өлзийт сумын Эрүүл мэндийн төв	42,324,142.00	42,324,142
	<b>Нийт дүн</b>		<b>2,273,137,356.00</b>	<b>2,273,137,356.00</b>
			(хоёр тэрбум хоёр зуун далан гурван сая нэг зуун гучин долоон мянга гурван зуун тавин зургаан)	(хоёр тэрбум хоёр зуун далан гурван сая нэг зуун гучин долоон мянга гурван зуун тавин зургаан)